

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Даланзадгад хот
2018 он

Агуулга

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа</p> <p>Аудитын менежер Ж.Болормаа</p> <p>Аудитор Г.Шижирболд П.Батцэцэг Б.Номинцэцэг</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу</p> <p>ХАЯГ: Өмнөговь аймаг Нутгийн удирдлагын ордон 305 тоот</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт</p> <p>Бүлэг 1 Орон нутгийн төсвийг бодитой төлөвлөсөн боловч хуваарилалт дутуу хийгдсэнээс төсвийн орлогын төлөвлөгөөг таслахад хүргэсэн байна.</p> <p>Бүлэг 2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 17.847,8 сая төгрөгөөр тасалсан байна.</p> <p>Бүлэг 3 2018 оны 09 сарын 30-ний байдлаа өр, авлага үүсгэж ажилласан байна.</p> <p>Бүлэг 4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 38 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна.</p> <p>Дүгнэлт Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал</p>
---	--



Товчилсон үгийн жагсаалт

СЯ	Сангийн яам
ЗГ	Засгийн газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг үндэслэн Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ төлөвлөгөөний дагуу 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад гүйцэтгэлийн аудит хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Өмнөговь аймгийн төсвийн гүйцэтгэл, төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган Үндэсний аудитын газарт нэгтгүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх,
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.

ХАМРАХ ХҮРЭЭ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаарх төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж горим сорилын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТ ХИЙХЭД АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Аудитыг Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа удирдаж, аудитын менежер Ж.Болормаа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Шижирболд, Б.Батцэцэг, Б.Номинцэцэг нар 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Бүлэг 1

Орон нутгийн төсвийг бодитой төлөвлөсөн боловч хуваарилалт дутуу хийгдсэнээс төсвийн орлогын төлөвлөгөөг таслахад хүргэсэн байна.

Монгол улсын төсвийн тухай хуулийн 65.1.1 “Тухай шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах”, гэсэн заалтыг хэрэгжүүлэн 2017 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 5/4 тоот Өмнөговь аймгийн ИТХ-ын тогтоолоор 2018 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 171,389.1 сая төгрөгөөр батлуулж ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 65.1.7 “Аймаг нийслэлийн жилийн төсвийн сар улирлын хуваарийг баталж мөрдүүлэх”, 8.7.1. “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батлах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/1337 тоот захирамжаар төсвийн сар, улирлын хуваарийг баталж ажилласан байна. 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/08 тоот захирамжаар төсвийн сар улирлын хуваарийг шинэчлэн баталж ажилласан байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг салгаж авч үзвэл улсын төсвийн орлогод 16,292.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 30,916.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 189,8 хувиар, аймгийн төсвийн орлогод 118,278.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 100,430.7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 84.9 хувиар тус тус биелүүлэн ажилласан байна.

Нийт өссөн дүнгээрээ улс болон аймаг, орон нутгийн төсөвт тусгай зориулалтын шилжүүлэг хассан дүнгээр 134,571.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 131,346.8 сая төгрөг төвлөрүүлж 97.6 хувиар төлөвлөгөөг биелүүлэн ажилласан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл нийт дүнгээр:
/сая төгрөг /

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
АЙМГИЙН НИЙТ ДҮН	134,571.0	131,346.8	97.6
УЛСЫН ТӨСӨВ	16,292.5	30,916.0	189.8
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	118,278.5	100,430.7	84.9

Төсвийн тухай хуулийн 23.4, Татварын ерөнхий хуулийн 7.3-д тус тус заасан улсын төсөвт хамаарах орлогыг сумдууд 6 нэр төрлөөр 17.6-147.6 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар авч үзвэл:

УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН 2018 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

/мянган төгрөг/

№	Сум, байгууллагын нэр	Улсын төсвийн орлого		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Баяндалай	5,710.9	14,106.1	247.0
2	Баяновоо	31,728.5	22,355.5	70.5
3	Булган	10,619.8	26,298.9	247.6
4	Гурвантэс	6,341,337.6	8,668,518.8	136.7
5	Мандаловоо	22,870.7	29,536.8	129.1
6	Манлай	21,327.9	25,083.9	117.6
7	Ноён	3,144,655.6	5,862,942.7	186.4
8	Номгон	13,721.1	11,212.4	81.7
9	Сэврэй	7,771.5	27,066.1	348.3
10	Ханбогд	4,825,258.2	8,350,621.7	173.1
11	Ханхонгор	10,374.7	4,550,440.3	43860.9
12	Хүрмэн	8,058.2	11,277.6	140.0
13	Цогтовоо	12,319.0	19,337.2	157.0
14	Цогтцэций	546,143.1	507,197.6	92.9
15	Даланзадгад	18,850.9	18,907.9	100.3
16	Татварын хэлтэс	1,271,752.3	2,771,146.5	217.9
Дүн		16,292,500.0	30,916,050.0	189.8

Хүснэгтээс харахад Баян-Овоо, Номгон, Цогтцэций сумдууд 7.1-29.5 хувиар улсын төсвийн орлогын төлөвлөгөөг тасалж бусад 12 сум давуулан биелүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23.6, 23.8, Татварын ерөнхий хуулийн 7.4-д тус тус заасан орон нутгийн төсөвт хамаарах орлогыг аймгийн хэмжээнд 17,847.8 сая төгрөгөөр буюу 15.1 хувиар төсвийн орлогын төлөвлөгөөг тасалж ажилласан байна. Орон нутгийн төсвийн орлогын мэдээг татварын нэр төрлөөр авч үзвэл:

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2018 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ОРЛОГЫН МЭДЭЭ

/ТАТВАРЫН НЭР ТӨРЛӨӨР/

/мянган төгрөг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Нийт орлого	118,278,561.4	100,430,756.1	84.9
А. Урсгал орлого	118,228,561.4	100,394,985.8	84.9
I.Татварын орлого	73,967,908.1	62,463,798.2	84.4
1. Хүн амын орлогын албан татвар	38,119,711.2	27,826,980.1	73.0
1.1 Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	37,806,390.4	26,552,442.0	70.2
1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(1,200,000.0)	(966,970.5)	80.6
1.4 Хувь хүний орлогын албан татвар	819,257.7	204,572.1	25.0

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

/Ноосны урамшуулал/			
1.5 Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар /ҮАО/	224,999.8	968,790.0	430.6
1.6 ИҮХЭХБор албан татвар	20,000.0	101,526.9	507.6
1.7 Хадгаламжийн хүүгийн орлого	449,063.3	966,619.6	215.3
2. Өмчийн татвар	16,824,248.0	17,015,121.3	101.1
2.1 Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,800,000.0	16,988,533.8	101.1
2.2 Галт зэвсгийн албан татвар	24,248.0	26,587.5	109.6
3. Дотоодын бараа үйлчилгээний татвар	2,250,000.0	2,404,595.9	106.9
3.1 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	2,250,000.0	2,404,595.9	106.9
4. Бусад татвар	16,773,948.9	15,217,100.8	90.7
4.1 Улсын тэмдэгтийн хураамж	183,564.9	245,529.0	133.8
4.2 Хог хаягдлын хураамж	212,116.7	196,095.3	92.4
4.3 Үйлдвэр үйлчилгээний усны төлбөр	11,600,000.0	10,703,617.1	92.3
4.4 Газрын төлбөр	2,475,150.0	2,806,600.5	113.4
4.5 Дуудлага худалдааны орлого	1,500,000.0	-	0.0
4.6 Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр	168.6	230.1	136.5
4.7 Ус ашигласны төлбөр	64,029.0	23,476.6	36.7
4.8 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	738,919.7	1,240,558.9	167.9
4.9 Бусад татвар, төлбөр, хураамж	-	993.3	
II. Татварын бус орлого	44,260,653.3	37,931,187.6	85.7
2.1 Хувьцааны ноогдол ашиг	32,517,570.0	34,001,776.4	104.6
2.2 Хүү, торгуулийн орлого	206,314.2	34,556.2	16.7
2.3 Бусад хүү торгуулийн орлого	631,215.6	2,097,547.6	332.3
2.4 Түрээсийн орлого	1,000.0	10,417.9	1041.8
2.5 Төсөвт газрын өөрийн орлого	10,378,220.3	1,647,679.4	15.9
2.6 Бусад нэр заагдаагүй орлого	526,333.2	139,210.2	26.4
Б. Хөрөнгийн орлого	50,000.0	35,770.3	71.5
Хөрөнгө худалдсаны орлого	50,000.0	35,770.3	71.5

Төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр таслахад хүргэсэн гол шалтгаан:

- 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд орсон өөрчлөлтийн улмаас орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө тухайн нэр төрөл дээр 11,253.9 сая төгрөгөөр тасалдсан байна.
- Төсөвт байгууллагын өөрийн орлого 8,730.5 сая төгрөгөөр тасалдсан нь орон нутгийн төсвийн орлого таслахад гол нөлөө үзүүлсэн байна.
- Үйл ажиллагааны орлогод хамаарах ноосны урамшууллын орлого аймгийн төсвийн орлогын 100110000901 тоот дансанд 6 дугаар сарын 27-ны өдөр 125,4 сая төгрөг орсон боловч одоог хүртэл сумдад хуваарилалт хийгдээгүйн улмаас бүх сумд үйл ажилагааны орлого 32.4-98.5 хувиар тасалдалтай байна.

- Ус ашигласны төлбөрийн орлого сүүлийн 3 жилийн гүйцэтгэл дунджаар 15,150.6 сая төгрөг байхад 8,259.3 сая төгрөгөөр нэмж хэт өндөр төлөвлөгөө батлуулсан нь төсвийн орлогын төлөвлөгөө нэр төрлөөр тасрахад хүргэсэн байна.

Иймд төсвийн тухай хуулийн 41.2 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, 41.2.4 “Төсвийн сар улирлын хуваарийг баримтлаж ажиллах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн Төсвийн тухай хуулийн 40.4. “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна” 40.4.1 “Төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах” гэсэн төсвийн тухай хуулийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бүлэг 2

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 17.847,8 сая төгрөгөөр тасалсан байна.

2018 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 17,847.8 сая төгрөгөөр тасалж ажилласан байна. Төсвийн орлогын төлөвлөгөөг зарим нэг нэр төрөл дээр үндэслэл багатай төлөвлөж, мэргэжлийн байгууллагын саналд үндэслэж сар улирлын хуваарилалт хийгдээгүй ажилласан байна. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл:

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН 2018 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
/СУМДААР/**

№	Сум, байгууллагын нэр	төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/	
			гүйцэтгэл	Хувь
1	Баяндалай	162,261.90	142,521.30	87.8
2	Баяновоо	356,800.30	451,740.10	126.6
3	Булган	157,641.20	119,857.09	76.0
4	Гурвантэс	4,685,386.10	3,575,661.94	76.3
5	Мандаловоо	138,669.30	104,077.96	75.1
6	Манлай	534,406.70	329,751.40	61.7
7	Ноён	238,675.80	218,392.00	91.5
8	Номгон	162,933.40	163,492.95	100.3
9	Сэврэй	235,095.00	192,020.50	81.7
10	Ханбогд	42,684,293.30	37,633,450.65	88.2
11	Ханхонгор	383,249.10	430,332.72	112.3
12	Хүрмэн	209,498.00	187,857.64	89.7
13	Цогтовоо	149,433.90	129,778.50	86.8
14	Цогтцэций	16,731,357.60	14,100,518.57	84.3
15	Даланзадгад	2,452,979.00	1,740,318.58	70.9
16	Татварын хэлтэс	7,897,375.00	6,093,631.91	77.2
17	СТСХэлтэс	41,098,505.80	34,817,352.28	84.7
Дүн		118,278,561.4	100,430,756.1	84.9

Хүснэгтээс харахад орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Баян-Овоо, Номгон, Ханхонгор сумдаас бусад сумдууд 8.5-38.3 хувиар төсвийн орлогын төлөвлөгөө тасалдуулж ажилласан байна.

3 дугаар улирлын байдлаар Татварын хэлтсийн мэдээнээс үзэхэд Манлай сумын үл хөдлөх хөрөнгийн албан татвар 5.8 хувийн, Булган сум хог хаягдлын хураамж 26.8 хувь, Мандал-Овоо сум газрын төлбөр 6.8 хувийн, Ноён сум ус ашигласны төлбөр 15.5 хувийн, Ханхонгор сум хог хаягдлын төлбөр 15.5 хувийн, Хүрмэн сум үл хөдлөх хөрөнгийн албан татвар 11.8 хувийн,

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

Даланзадгад сум цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар 16.9 хувийн, Татварын хэлтэс үл хөдлөх хөрөнгийн албан татвар 26.6 хувийн тус тус гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн орлогын төлөвлөгөөг хуваарилахад анхаарч үзэх хэрэгтэйг харуулж байна. Мөн Татварын хэлтэс Санхүү төрийн сангийн хэлтэс хоорондын уялдааг нягт сайжруулж улмаар сумын татварын байцаагч, санхүү албаны дарга нар хамтын ажиллагаагаа дээшлүүлэн төсвөө батлуулах, сарчилсан хуваарь боловсруулахдаа цаашид анхаарч нягт хамтарч ажиллах шаардлагатай байна.

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдөр, Бууны албан татварын тухай хууль 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр тус тус хүчингүй болсон байхад аймгийн хэмжээний нэгтгэл мэдээн дээр хүчингүй болсон хуулийн үг үсэг хэрэглэж байгаа нь энэ хуулийн талаар ойлголт тааруу байгааг харуулж байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс төсвийн орлогын мэдээний төлөвлөгөө гүйцэтгэлийг зөрүүтэй мэдээлж ажилласан байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2018 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ОРЛОГЫН МЭДЭЭ
/мянган төгрөг/

Төрийн сангийн мэдээ		Татварын мэдээ		зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Нийт орлого	118,278,561.4	100,430,756.1	117,953,021.3	101,412,943.4	325,540.10 (15,216.81)
А. Урсгал орлого	118,228,561.4	100,394,985.8	117,903,021.3	101,377,173.1	325,540.10 (15,216.81)
I.Татварын орлого	73,967,908.1	62,463,798.2	73,967,908.1	63,664,887.7	- (234,119.04)
1. Хүн амын орлогын албан татвар	38,119,711.2	27,826,980.1	38,119,711.20	28,993,756.90	- (199,806.30)
1.1 Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	37,806,390.4	26,552,442.0	36,606,390.40	26,749,285.70	1,200,000.00 (196,843.71)
1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(1,200,000.0)	(966,970.5)			(1,200,000.00) (966,970.50)
1.3 Хувь хүний орлогын албан татвар /Ноосны урамшуулал/	819,257.7	1,095,391.2	819,257.70	204,572.10	- 890,819.12
1.4 Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар /ҮАО/	224,999.8	77,970.9	224,999.80	932,294.40	- (854,323.46)
1.5 ИҮХЭХБор албан татвар	20,000.0	101,526.9	20,000.00	117,850.80	- (16,323.90)
1.6 Хадгаламжийн хүүгийн орлого	449,063.3	966,619.6	449,063.30	989,753.90	- (23,134.34)
2. Өмчийн татвар	16,824,248.0	17,015,121.3	16,824,248.00	17,018,775.70	- (3,654.35)
2.1 Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,800,000.0	16,988,533.8	16,800,000.00	16,992,245.20	- (3,711.35)
2.2 Галт зэвсгийн албан татвар	24,248.0	26,587.5	24,248.00	26,530.50	- 57.00
3. Дотоодын бараа үйлчилгээний татвар	2,250,000.0	2,404,595.9	2,250,000.00	2,407,168.00	- (2,572.13)
3.1 Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	2,250,000.0	2,404,595.9	2,250,000.00	2,407,168.00	- (2,572.13)
4. Бусад татвар	16,773,948.9	15,217,100.8	16,773,948.90	15,245,187.10	- (28,086.27)
4.1 Улсын тэмдэгтийн хураамж	183,564.9	245,529.0	183,564.90	242,010.90	- 3,518.12
4.2 Хог хаягдлын хураамж	212,116.7	196,095.3	212,116.70	205,314.10	- (9,218.79)

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

4.3 Үйлдвэр үйлчилгээний усны төлбөр	11,600,000.0	10,703,617.1	11,600,000.00	10,703,701.00	-	(83.87)
4.4 Газрын төлбөр	2,475,150.0	2,806,600.5	2,475,150.00	2,807,492.90	-	(892.44)
4.5 Дуудлага худалдааны орлого	1,500,000.0	-	1,500,000.00		-	-
4.6 Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр	168.6	230.1	628.60	230.10	(460.00)	-
4.7 Агнуурын нөөц ашигласны төлбөр	-	-		1,540.00	-	(1,540.00)
4.8 Ус ашигласны төлбөр	64,029.0	23,476.6	63,569.00	22,503.40	460.00	973.25
4.9 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	738,919.7	1,240,558.9	738,919.70	1,262,394.70	-	(21,835.85)
4.10 Бусад татвар, төлбөр, хураамж	-	993.3			-	993.30
II. Татварын бус орлого	44,260,653.3	37,931,187.6	43,935,113.20	37,712,285.40	325,540.10	218,902.24
2.1 Хувьцааны ноогдол ашиг	32,517,570.0	34,001,776.4	32,517,570.00	34,001,776.40	-	-
2.2 Хүү, торгуулийн орлого	206,314.2	34,556.2	290,735.10	636,561.80	(84,420.90)	(602,005.60)
2.3 Бусад хүү торгуулийн орлого	631,215.6	2,097,547.6	629,294.70	1,399,009.70	1,920.90	698,537.90
2.4 Түрээсийн орлого	1,000.0	10,417.9	1,000.00	10,417.90	-	-
2.5 Төсөвт газрын өөрийн орлого	10,378,220.3	1,647,679.4	10,378,220.30	1,647,679.40	-	(0.02)
2.6 Бусад нэр заагдаагүй орлого	526,333.2	139,210.2	118,293.10	16,840.20	408,040.10	122,369.95
Б. Хөрөнгийн орлого	50,000.0	35,770.3	50,000.0	35,770.3	-	-
Хөрөнгө худалдсаны орлого	50,000.0	35,770.3	50,000.00	35,770.30	-	-

Хүснэгтээс харахад 3 дугаар улирлын төсвийн орлогын мэдээнд төсвийн орлогын төлөвлөгөөг 325,5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 15,2 сая төгрөгөөр зөрүүтэй мэдээлж ажилласан байна.

Бүлэг 3

2018 оны 09 сарын 30-ний байдлаа өр, авлага үүсгэж ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 41.1 “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх, нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн төсвийн зарлагыг аймгийн ИТХ-аар батлуулан сар улирлын хуваарийг Засаг даргын захирамжаар баталгаажуулан ажилласан байна. Аймгийн хэмжээнд 2018 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 171,389.1 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оноос 68,308.8 сая төгрөгөөр буюу 66.3%-иар өссөн байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 146,449.5 сая төгрөг зарцуулахаас, гүйцэтгэлээр 116,385.7 сая төгрөг зарцуулж, 79.5%-ийн гүйцэтгэлтэй байна.

Нийт зардлын бүтцийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

/сая.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт /+/ хэтрэлт /-/	гүйцэт гэлд эзлэх хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	146,449.49	116,385.68	30,063.81	79%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	16,926.10	16,111.16	814.94	95%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,046.51	1,935.48	111.03	95%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,592.24	2,620.28	971.96	73%
Хангамж, бараа материалын зардал	1,231.18	1,096.48	134.70	89%
Нормативт зардал	1,609.83	1,349.85	259.98	84%
Эд хогшил, урсгал засварын зардал	409.99	321.42	88.57	78%
Томилолт, зочны зардал	178.20	123.00	55.20	69%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,027.46	1,669.65	357.81	82%
Бараа үйлчилгээний бусад зардал	7,565.49	4,232.52	3,332.97	56%
ТАТААС	330.80	307.55	23.25	93%
Засгийн газрын дотоод шилжүүлэг	58,764.69	58,205.60	559.09	99%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,208.86	23,846.66	22,362.21	52%
Тэтгэмж урамшуулал	5,558.12	4,566.01	992.11	82%

Дээрх хүснэгтээс харахад нийт зарлагын 50%-ийг Засгийн газрын дотоод шилжүүлэг, 20.5%-ийг хөрөнгийн зардал, 13.8%-ийг Цалин хөлс болон нэмэгдэл

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

урамшууллын зардал, бусад 15,7%-ийг бараа үйлчилгээ болон бусад урсгал зардлууд эзэлж байна.

ТЭЗ-ийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг төсвийн захирагчаар авч үзэхэд нийт зарцуулалтын 83.33%-ийг аймгийн Засаг дарга, 14.37%-ийг Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд, 1.95%-ийг Эрүүл мэндийн сайд, 0.15%-ийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд үлдсэн 0.2%-ийг Барилга, хот байгуулалтын сайдын зарлага тус тус эзэлж байна.

Сая төгрөг

№	Сайдын багц	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт(+) хэтрэлт(-)	хувь
1	Аймгийн Засаг дарга	124,724.25	96,979.79	27,744.47	83.33%
2	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд	18,830.16	16,727.73	2,102.44	14.37%
3	Эрүүл мэндийн сайд	2,441.51	2,273.42	168.09	1.95%
4	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	200.39	175.24	25.15	0.15%
5	Барилга, хот байгуулалтын сайд	253.18	229.51	23.67	0.20%
Нийт дүн		146,449.49	116,385.68	30,063.81	100%

Сайдын багцын төсвийн зарлагын гүйцэтгэлийг 2017 оны мөн үетэй харьцуулан үзэхэд:

Сая төгрөг

№	Сайдын багц	Гүйцэтгэл 2017он	Гүйцэтгэл 2018 он	өсөлт +, бууралт-	хувь
1	Аймгийн Засаг дарга	52,182.90	96,979.79	44,796.89	85.85
2	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд	16,913.40	16,727.73	(185.67)	(1.10)
3	Эрүүл мэндийн сайд	2,197.80	2,273.42	75.62	3.44
4	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	78.30	175.24	96.94	123.80
5	Барилга, хот байгуулалтын сайд	144.20	229.51	85.31	59.16
Нийт дүн		71,516.60	116,385.68	44,869.08	

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтэнд 124.7 тэрбум төгрөгийг төлөвлөж, 97.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 77.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.1 “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх, нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн төсвийн зарлагыг аймгийн иргэдийн Төлөөлөгдчийн Хурлаар батлуулан сар улирлын хуваарийг Засаг даргын захирамжаар баталгаажуулан ажилласан байна.

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ /ӨССӨН ДҮНГЭЭР/			
/Эдийн засгийн ангилалаар/			
НИЙТ ЗАРЛАГА	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	мян.төгрөг хувь
	124,724,252.80	96,979,787.40	77.8%
УРСГАЛ ЗАРДАЛ	78,515,388.80	73,133,128.60	93.1%
Үндсэн цалин	3,142,584.20	3,027,819.80	96.3%
Нэмэгдэл	498,326.90	429,709.50	86.2%
Унаа хоолны хөнгөлөлт	128,873.70	114,467.70	88.8%
Урамшуулал	47,700.00	36,927.00	77.4%
Гэрээт ажлын хөлс	265,982.50	264,434.40	99.4%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	491,790.50	461,926.60	93.9%
Гэрэл, цахилгаан	201,228.90	168,214.20	83.6%
Түлш, халаалт	374,582.80	303,934.40	81.1%
Цэвэр бохир ус	42,405.20	24,442.90	57.6%
Байрны түрээс	10,237.50	-	0.0%
Бичиг хэрэг	59,949.40	50,649.80	84.5%
Тээвэр, шатахуун	372,617.40	359,477.10	96.5%
Шуудан холбоо интернетийн төлбөр	123,611.60	91,219.70	73.8%
Ном, хэвлэл	9,555.50	5,926.00	62.0%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	238,159.80	217,995.60	91.5%
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	43,846.00	35,954.30	82.0%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	34,837.10	21,304.90	61.2%
Багаж, техник хэрэгсэл	28,752.00	19,559.20	68.0%
Тавилга	-	-	0.0%
Урсгал засвар	170,835.90	130,392.70	76.3%
Гадаад албан томилолт	10,500.00	4,420.30	42.1%
Дотоод албан томилолт	126,007.40	95,172.40	75.5%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,818,529.40	1,499,876.40	82.5%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	0.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	6,946,094.00	3,676,070.90	52.9%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,387.20	44,636.10	68.3%
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	330,801.60	307,551.60	93.0%
Засгийн газрын дотоод шилжүүлэг	58,764,693.00	58,205,603.00	99.0%
нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж	3,993,265.20	3,454,758.50	86.5%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-	0.0%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,872.00	19,548.10	45.6%

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	131,362.10	61,135.50	46.5%
Хөрөнгийн зардал	46,208,864.00	23,846,658.80	51.6%

2018 оны эхний 9 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагууд 399.0 сая төгрөгийн өглөг, 2,081.6 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” 41.1 “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хувиарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, мөн Төсвийн тухай хуулийн 41.2.2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, төсвийн тухай хуулийн 41.2.4 “Төсвийн сар, улирлын хуваарийг баримтлаж ажиллах” заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул аймгийн Засаг даргад өр, авлага барагдуулах албан шаардлага хүргүүллээ.

Төсвийн байгууллагын өглөгийг төсвийн ерөнхийлөн захирагчаар нь 2017, 2018 оны байдлаар харьцуулахад өмнөх оноос 324,6 сая төгрөгөөр өссөн байна.

Бүлэг 4

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 38 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих ба хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сард гаргах бөгөөд эцсийн үнэлгээг шалгуурын дагуу 2020 оны 4 дүгээр сард гаргана. Дэд хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- Орон нутгийн төсөв
- Төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хандив
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хандив тусламж
- Бусад санхүүгийн эх үүсвэрээс

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний гүйцэтгэл

№	Онууд	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжүүлэх дүн	Захирамж, шийдвэр гэрээний дүн	Олгосон санхүүжилтын дүн
1	2017.9 сар	62	18,187.7	15,065.7	12,681.3
2	2018.9 сар	38	20,753.7	30,233.5	12,165.04
Нийт			38,941.5	45,299.3	24,846.30

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний гүйцэтгэлээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь 24- өөр бага боловч мөнгөн дүн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 2,565.9 сая төгрөгөөр өссөн, олгосон санхүүжилт нь 516,2 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс үзэхэд оновчтой, нэн шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийг анхаарах нь чухал байна.

Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл , арга хэмжээний гүйцэтгэл

№	Он ,сар	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжүүлэх дүн	Захирамж, шийдвэр гэрээний дүн	/Сая төгрөгөөр/
					Олгосон санхүүжилтын дүн
1	2017.9 сар	17	5,037.8	4,582.2	2,363.2
2	2018.9 сар	10	7,898.06	7,009.5	3,634.5

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоо нь өмнөх оны мөн үеийнхээс 7 –оор их санхүүжүүлэх дүн нь 2,860.2 сая төгрөгөөр их, олгосон санхүүжилт нь 1,271.2 сая төгрөгөөр их байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл , арга хэмжээ

/Сая төгрөгөөр/

№	Он ,сар	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжүүлэх дүн	Захирамж, шийдвэр гэрээний дүн	Олгосон санхүүжилтын дүн
1	2017.9 сар	9	9,967.3	5,154.9	3,125.7
2	2018.9 сар	9	8,999.4	12,806.1	5,481.7

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний санхүүжүүлэх дүн нь 967,9 сая төгрөгөөр буурсан, олгосон санхүүжилт нь 2.355,9 сая төгрөгөөр өссөн байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04- ний өдрийн 5/4 дүгээр тогтоолын наймдугаар хавсралт Орон нутгийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжих хөтөлбөр, арга хэмжээний төслийг 4,836.9 сая төгрөгөөр төсөвлөсөн байна. Үүнээс 2018 оны 09 дүгээр сарын байдлаар 55.4 хувь буюу 2,681.7сая төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжсэн байна.

2017, 2018 онуудад хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний харьцуулалт

/Сая төгрөгөөр/

№	Он сар	Төсөл арга хэмжээний тоо	Нийт төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	2017.9 сар	20	4,780.6	1,300.7	3,479,8	27,2
2	2018.9 сар	22	4,836.9	2,681.7	2.155,1	55,4

Өмнөх оны мөн үеийн хөтөлбөр, төсөл арга хэмжээтэй харьцуулахад нийт төлөвлөгөө нь 56,3 сая төгрөгөөр нэмэгдсэн, гүйцэтгэлийн хувь нь 28.3 хувиар өссөн, хүлээгдэж буй гүйцэтгэл 1,324.7 сая төгрөгөөр буурсан байна

Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэнд тавих дотоод хяналтыг АЗДТГ-ын Хяналт- Шинжилгээ, Үнэлгээ, Дотоод Аудитын хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 15- дугаар зүйл , Хөгжлийн бодлого , төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйл Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, 14.6-д *“Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ”, 15 дугаар зүйл Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр – д*

заасны дагуу хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж дүгнэлт гарган зөвлөмж өгч ажилладаг байна.

Уг тайлан дүгнэлт, зөвлөмжийг аймгийн ИТХ-д танилцуулан, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг байна. Мөн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан *“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”* болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэнд сар, улирлын хуваарьт төлөвлөгөөний дугуу дотоод хяналт хийж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 15,1 хувиар тасалдсан байна
2. Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр таслан жигд ажиллагааг хангаж ажиллаагүй, төсвийн орлогын төлөвлөгөөг хуваарилахад мэргэжлийн байгууллагын саналд тулгуурлаж хуваарилалт хийгдээгүй байна.
3. 2018 оны 09 сарын 30-ний байдлаар өр, авлага үүсгэж ажилласан байна.
4. ТЕЗ-ын

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн Өмнөговь аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга нарт зөвлөх нь:

- ✚ Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлж ажиллах.
- ✚ Төсвийн орлогын мэдээг Татварын хэлтэстэй сар бүр нийлж үнэн зөв мэдээлж байх
- ✚ Төсвийн сар улирлын хуваарь гаргахдаа мэргэжлийн байгууллага болон сумдын санхүүгийн алба, сумдын татварын байцаагчдын саналд тулгуурлан баталж байх
- ✚ Төсвийн тухай хуулийн 40, 41-р зүйлд заасан үүргээ хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй ажиллах.



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/28

Далмаадагва

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, дахь заалт, мөн 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дах төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх" –ийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг санхүүгийн аудитын баг /Г.Шижирболд/-т үүрэг болгосугай.

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ж.БОЛОРМАА

D:Bichig hereg/Tushaal-B-A4

713092